

## 7

## БАРУУН БҮС ДЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Д.Нар-Од

Нийгэм эдийн засгийн өсөлт, хөгжлийн үндсэн гол хүчин зүйл нь хөрөнгө оруулалт бөгөөд хөрөнгө оруулалтын үр дүнд тодорхой салбарын үйл ажиллагааг дэмжих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үндсэн нөхцөл бүрдэх бүрэн боломжтой.

Хөрөнгө оруулалт бол зорилгод нь хүргэх зүйл юм. Хөрөнгө оруулалтын үндсэн үйл ажиллагаа нь аж ахуйн нэгжийн төвшинд явагдах бөгөөд аж ахуйн нэгжийн санхүү нь улс орны санхүүгийн тогтолцооны үндэс нь болдог учраас чухамхүү энд л хөрөнгө оруулалтын бодлого, санхүүжилтын үр ашиг ямар байгаагаас тухайн нэгж байгууллагын төдийгүй улс орны хөгжил шууд хамаардаг. Иймээс аж ахуйн нэгж бүр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаандаа маш нарийн тооцоолол үндэслэлтэйгээр мэргэжлийн үүднээс хандаж, хөрөнгө оруулалтыг удирдлагын өндөр түвшинд байлгах зайлшгүй шаардлагатай. Хөрөнгө оруулалтыг тодорхой аж ахуйн нэгж, нутаг дэвсгэрээр нь тухайлбал баруун бүс дэх хөрөнгө оруулалтын нөхцөл байдлыг авч үзэн ирээдүйгээ харан оновчтой сонголт хийж байгаа эсэх, үр ашигтай хэмнэлттэй бодлого явуулж байгаа эсэх, цаашлаад жилээс жилд дорвитой ямар ахиц гарч байна вэ? гэдгийг судлан авч үзэж дүн шинжилгээ хийх үүднээс хөрөнгө оруулалтын орчны судлалгааг 2006 онд ARC олон улсын байгууллагын санхүүжилтээр баруун бүсийн 5 аймагт хийлээ. Баруун бүсийн 5 аймагт дэд бүтцийн хөгжлөөрөө харьцангуй хоцрогдсон ялангуяа үйлдвэрлэлийн дэд бүтцийн салбаруудаас авто замын сүлжээ үнэхээр хоцрогдож хөрсөн зам зонхилсон байдалтай байна. Орчин үеийн замын сүлжээ байхгүй байгаагаас баруун бүсийн хэмжээн дэх аливаа бараа таваар, үйлдвэрлэл үйлчилгээний өртөг өндөр байх нөхцлийг бий болгож байна. Үүнтэй уялдуулан “Мянганы зам” тавих ажлыг эрчимжүүлэх энэ бүтээн байгуулалтанд Баруун бүсийн хамтын үйл ажиллагаа оролцоог улам сайжруулан идэвхижүүлэх шаардлагатай юм. Үүний нэг илрэл нь Баруун бүсийн замын босоо тэнхлэгийн эхлэл болох Ховд аймагт Ярант-Булганы 65 км хатуу хучилттай авто зам баригдаж байна. Төр засгаас баруун бүсийн авто

замыг хүндрэлтэй байдлыг мэдэрч сүүлийн жилүүдэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалтыг улсын төсвөөс гарган санжүүжүүлэх ажил хийгдсээр байна.

Баруун бүсийн хувьд эрчим хүчний асуудал ч гэсэн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Одоогийн байдлаар зөвхөн Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн төв эдгээр аймгуудын цөөн тооны сумдыг ОХУ-ын Красноярский эрчим хүчний нэгдсэн системээс гадаад орноос хамааралтай цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Бүсийн бусад хоёр аймгийн төв олон сумдад дизель цахилгаан станц зонхилж байна. Дизель станц нь түлш их иддэг, нөгөө талаар түлш худалдан авах санхүүгийн чадавхи муугаас эрчим хүчний хомсдол, өөрөөр хэлбэл эрчим хүчний хязгаарлалт их байгаагаас техник тоног төхөөрөмж ажиллуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжинд хязгаарлалт хийж байна. Нөгөө талаас энэ хүнд байдал нь ажилтан албан хаагчдын үр бүтээлтэй ажиллах байдлыг бууруулаад зогсохгүй хөдөлмөрийн бүтээмжийг нь саармагжуулж, чанар муутай болгож байна. Сүүлийн жилүүдэд баруун бүсийн хэмжээнд Усан цахилгаан станц барьж байгуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж байна. Тухайлбал: Баруун бүсийн аймгуудыг цахилгаан эрчим хүчээр хангах чадал бүхий Дөргөний Усан цахилгаан станц, Ховд аймгийн алслагдсан баруун 3 сумыг эрчим хүчээр хангах Үенчийн усан цахилгаан станц, Увс аймагт баригдаж буй Улаамбоомын усан цахилгаан станц, бүсийн хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэх Тайширын усан цахилгаан станцын барилга угсралтын ажил амжилттай явагдаж байгаа ба энэ нь Алтай, Улиастай хот орчмын 7-8 сумыг ИМВТ-ын цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж хангах бололцоотой юм.

Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын орчин, нөхцөл уур амьсгал сайжрах хандлагатай болж байгаа төдийгүй Монгол улсын хэмжээнд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж түүний бүтэц санхүүжилтэнд өөрчлөлт орж байна.

Улсын хэмжээний нийт хөрөнгө оруулалтыг авч үзвэл: 1995 онд 91.5 тэрбумын хөрөнгө оруулалт 2003 онд 334.4 тэр бусын хөрөнгө оруулалт харин 2005 онд 578.9 тэрбумын хөрөнгө оруулалт хийгдэж хөрөнгө оруулалтын хэмжээ өсөлттэй байна. 2003 оныг суурь болгон харьцуулж үзвэл 1995 оноос 2003 он хүртэл хөрөнгө оруулалтын хэмжээ 242.3 буюу 3.6 дахин 2003 оноос 2005 он хүртэл 244.5 тэрбум буюу 73 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нийт улсын хэмжээний 2003 оны хөрөнгө оруулалтанд бид бүхний хийсэн судалгаагаар баруун бүсийн нийт хөрөнгө оруулалт нь 14.3 тэр бум буюу 4.3 хувийг эзлэж байсан бол 2005 оны улсын нийт хөрөнгө оруулалтанд 29.8 тэрбум буюу 5.2 хувийг эзлэж байна. Улсын хэмжээний нийт хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр нь авч үзвэл гадаад хөрөнгө оруулалт дийлэнхи хувийг эзлэж байдаг бол баруун бүс нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын дийлэнх хэсгийг улсын төсвийн хөрөнгө оруулалт эзлэж буй хандлага илэрч байна. Иймээс гадаад хөрөнгө оруулалтыг хөдөө орон нутагт татах шаардлагатай байна. 2003 оны байдлаар улын хэмжээний нийт хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг барилга угсралт их засварын ажил 38.2% буюу



131.9 тэр бумын хөрөнгө оруулалтаар эзлэж байсан. Сүүлийн жилүүдэд машин тоног төхөөрөмжөөр буюу биет хэлбэрээр хийх хөөрнгө оруулалт өсөх хандлагатай болжээ. Гэтэл хөдөө орон нутагт баруун бүсийн хэмжээнд хийгдэж буюу хөрөнгө оруулаалтын 60 орчим хувийг барилга угсралт их засварын ажилд зарцуулж байна. 2003 онд барилга угсралт их засварт улсын хэмжээнд 104921.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэний 6830.4 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажил баруун бүсэд 2004 онд нийт 133862.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээс баруун бүсэд 9958.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт 2005 онд 147087.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээс баруун бүсэд 9713.6 сая төгрөгийн барилга угсралт их засварын ажилд хөрөнгө оруулалт зарцуулжээ. Ямар ч салбарт хөрөнгө оруулалт хийснээр хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэх, ая духтай ажиллах, сурч боловсрох, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах нөхцөл байдал сайжирч нийгэм эдийн засагт эерэг таатай уур амьсгалыг бүрдүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын орчны судалгааг хийж байхад шууд ажиглагдсан нэгэн зүйл байлаа. Төсөвт байгууллагуудад улсын болон орон нутгийн төвлөрсөн сан, бусад төслийн нэгж, байгууллагуудаас оруулж буй хөрөнгө оруулалт нь барилга байгууламж барих, түүний завсар үйлчилгээ, тоног төхөөрөмж бий болгох чиглэлээр ихэнхи хувь нь хийгдэж байна. Энэ нь өсвөр насны хүүхдүүдийн сурч боловсрох таатай нөхцлийг бий болгож, хөдөө орон нутгийн ард иргэдэд эмнэлэгийн үйлчилгээ илүү чанартай мэргэжлийн түвшинд стандартын дагуу хүргэгдэх, цаг үеэсээ хоцролгүй мэдээ мэдээллийг олж авах боломжийг бий болгож байгаагаараа ач холбогдол бүхий зүйл болж байна. Баруун бүс нь төв орон нутаг тухайлбал Улаанбаатар бусад төвлөрсөн хот суурингаас алсад оршдог дэд бүтцийн хөгжил саармагдуу байдалтай байгаа ба түүнийг төр засгаас мэдэрч байгалийн баялагтаа тулгуурлан усан цахилгаан станц байгуулах ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж энэ тал дээр хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэх хандлагыг бий болгож байна. Баруун бүсийн гэгдэх Говь-Алтай аймаг, Ховд аймаг, Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Завхан аймгийн хэмжээнд сүүлийн жилүүдэд төрөл бүрийн төслийн нэгжүүд үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн нь бүс нутгийн хөгжил, ард иргэдийн амьжиргааны түвшин, худалдан авах чадвар зэрэгт сайнаар нөлөөлөөд зогсохгүй аймгуудын нийгэм эдийн засагт эерэг уур амьсгалыг бий болгоод байна. Нутаг дэвсгэрийн онцлог нөхцөл байдал, хөгжил дэвшилтээс нь хамааруулан хэрэгжиж буй төслийн нэгжүүд нь өөр өөр байх боловч нийтлэг нь зорилго бүхий байгаа нь ажиглагдлаа.

Хөрөнгө оруулалт бол тасралтгүй үйл ажиллагаа юм. Ямар нэг барилга барих юм уу, шинэ техник нэвтрүүлчихээд олон жил чимээгүй явж явж тэр нь хуучраад ирэхээр нь түүнийгээ засаж шинэчлэх талаар амь тэмцэн хөөцөлддөг тэр практик зах зээлийн харилцаанд тохирохгүй юм. Хөрөнгө оруулалт бол зах зээл дээр өрсөлдөх чадвараа байнга барьж байхын тулд техник технологую байнга шинэчилж ажиллах хүчний бүтээх чадварыг өндөр түвшинд байлгахын тулд техник технологую байнга шинэчилж, ажиллах хүчний бүтээх чадварыг

байнга өндөр түвшинд байлгахын тулд өнөө ба ирээдүйг холбосон үйл ажиллагааны гүүр байх ёстой. Улс орноо хөгжүүлэх

Монгол Улсын засгийн газрын 2005 оны 9-р сарын 28-ны өдрийн 202 тоот тогтоолоор бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг, түүний дотор “ Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр 2006-2015” –ыг батлан гаргаж үйл ажиллагааныхаа удирдлага болгохыг холбогдох газруудад үүрэг болгосон нь баруун бүсийн хөгжил дэвшилтэнд ач холбогдол бүхий зүйл болоод байна.

Баруун бүсийн хөрөнгө оруулалтын судлагааг хийснээр дараах хэд хэдэн дүгнэлтэнд хүрч байна.

1. Хөрөнгө оруулалтыг мөнгөн хөрөнгө, биет хөрөнгө, үнэт цаасаар хийх тохиолдлууд байдаг. Монгол улсын хэмжээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ихэнхи хэсгийг мөнгөн болон биет хөрөнгө оруулалт эзлэж байгаа хандлага бий. Хөдөө орон нутагт тухайлбал баруун бүсийн хэмжээнд хийгдэж буй хөрөнгө оруулалтын ихэнхи хэсгийг мөнгөөрхи хөрөнгө оруулалт эзлэж үлдэх хэсгийг нь биет хөрөнгөөрхи хөрөнгө оруулалт эзлэж байна Улсын хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалт дийлэнхи хувийг эзлэж байгаа бол хөдөө орон нутаг тухайлбал баруун бүсэд дотоодын хөрөнгө оруулалт тэр тусмаа улсын төвлөрсөн хөрөнгөөр санхүүжигдэн барилга, угсралтын завсар, машин тоног төхөөрөмж зэрэгт зарцуулагдаж байна
2. Гадаадын хөрөнгө оруулалт нь шууд бусаар төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ба анхлан бизнес эрхлэгчид, хөдөө орон нутгийн малчид, хөдөө аж ахуйн гэх мэт чиглэрээр хөрөнгө оруулалт хийгдэж байгаа ч орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ явуулж буй компаниуд хамрагдах боломж хомс. Эдгээр аж ахуйн нэгж нь банкны зээлээр хөрөнгө оруулалт хийн үйл ажиллагаагаа явуулж байгаа боловч банкны зээлийн хүү өндөр, хугацаа бага зэрэг нь хүндрэл учирч байдаг бололтой.
3. Зах зээлийн харилцаа өргөжихийн хэрээр хөрөнгө оруулалтын эх үүсвэр олширч, байна. Янз бүрийн төсөл боловсруулж зээл авах замаар хөрөнгө оруулалт хийх боллоо. Компаний урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөг уг төсөлдөө тусгаж чадаагүйгээс болоод хөрөнгө оруулалт хийгдсэн ч гэсэн дахин хөрөнгө оруулалт шаардагдах байдал ажиглагдаж байлаа. Иймээс компаний ирээдүйн үр өгөөж нь өндөр байх талаас нь харж байж төслийг санхүүжүүлэх шаардлагатай юм. Ирээдүйн орлогыг тооцоололд анхаарч ирээдүйн мөнгөний үнэ цэнэ дээр суурилан тооцоолох шаардлагатай юм шиг санагдаж байна.
4. Баруун бүсийн хэмжээнд нилээдгүй олон төсөл хөтөлбөрүүд хэргжиж тэдгээрээр дамжин ажлын байр бий болж ард иргэдийн амьжиргааны түвшинд нөлөө үзүүлж байна. Цаашид хөдөө орон нутагт олон чиглэлитэн төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна.
5. Баруун бүсэд хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх дотоод эх үүсвэр дутмаг, тэр тусмаа аж ахуйн нэгж байгууллагуудын орлогын эх үүсвэр,



ашигт ажиллагаа доогуур, төлбөрийн чадвар сул байгаагаас өөрийн хөрөнгөөрөө санхүүжүүлэх боломж хомс байна. Хөдөө орон нутагт орж ирж буй хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг мөнгөн хөрөнгөөрхи болон биет хөрөнгөөрхи хөрөнгө оруулалт эзлэж байна. Үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийх нь бүү хэл үнэт цаастай аж ахуйн нэгж хомс байна. Энэ нь аж ахуйн нэгж байгууллагын төлбөрийн чадвар сул, ноогдол ашиг олгох боломж хомс зэргээс үнэс цаасаарх хөрөнгө оруулалтын эх үүсвэр хязгаарлагдмал байдаг бололтой. Хөдөө орон нутаг гэлтгүй хөрөнгө оруулалтын бүх хэлбэрийг ашиглах нь хэрэгтэй юм.

6. Монголын хөдөө нутагт байгалийн цэвэр онгон байдал, нүүдлийн соёл иргэншлийн үнэт зүйлсийг хадгалан сэргээснээр дотоод гадаадын жуулчдыг татах боломжтой. Үүгээр үл барам байгалийн үзэсгэлэнт газар амралт, рашаан сувилал, урлаг соёлын бүтээгдэхүүнээр үйлчлэх нь хөрөнгө оруулагчдыг татах боломжтой юм.
7. Цаашид хөдөө орон нутагт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих, татах бололцоог бүрдүүлэх, үйлдвэрлэл, худалдаа эдийн засгийн онцлог объектыг хөгжүүлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмжих явдал илүү бодитой байна.

**Цаашид баруун бүсэд хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбар нь.:**

1. Дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх : Дэд бүтцээр бүрэн хангагдсанаар үйлдвэрлэл үйлчилгээ өргөжин тэлэх, иргэдийн тав тухтай амьдарч , сурч боловсрох бололцоогоор хангах таатай талтай.
2. Байгалийн өвөрмөц цогцолбор , ховор амьтан, ургамалын төрөл зүйл сайтай өргөн удам нутагт дэвсгэртэй учраас аялал жуучлалын чиглэлээр хөрөнгө оруулалтыг түлхүү татах ялангуяа хөдөө орон нутагт
3. Хөдөө аж ахуйн чиглэлээр ажиллах эдэлбэр цогцолбор сайтай тул хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг татах
4. Хөдөө орон нутагт эрдсийн түүхий эдийн нөөц элбэл тул түүний хайгуулын ажлыг эрчимжүүлж тэр чиглэлээр хөрөнгө оруулалтыг татах
5. Мал аж ахуй газар тариалангийн түүхий эд нөөцдөө түшиглэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж харьцангуй сайтай тул энэ чиглэлээр хөрөнгө оруулалт татах
6. Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор банкны урт хугацаатай зээл олгох замаар хөрөнгө оруулалтыг татах нэмэгдүүлэх
7. Улирлын чанартай мал аж ахуйн чиглэлээр үйлдвэрлэл явуулах боломжийг хайн хөрөнгө оруулалтыг татах
8. Хөрөнгө оруулалтыг хотоос хөдөө рүү чиглүүлэх

*Иймд хөрөнгө оруулалтыг макро эдийн засгийн зарим нэгэн үзүүлэлтийг өсөлтийг хангахад удирдлагын гол параметрээр чухалчлан авч үзэх шаардлагатай байна Засгийн газрын гадаад зээл, улсын төсвийн хөрөнгө оруулалтаас илүүгээр хувийн хэвшилд гадаад дотоодын шууд хөрөнгө оруулалтыг илүү түлхүү оруулахад анхаарах хэрэгтэй. Энэ нь хөрөнгө оруулалтын шаардлагатай салбарт нь оруулна гэсэн үг. Хөрөнгө*

*орзуулалтын хэмжээнд нь бус хөрөнгө оруулалтын үр ашиг өгөөжид нь анхаарлаа хандуулах цаг нэгэнт болжээ.*

*Хөрөнгө оруулалт гэдгийг жинхэнэ бодит утгаар нь биш зөвхөн хуучин элэгдсэн байшин байрилга засварлах , шинээр объект бий болгох мэтээр ойлгож байгаа нь асар буруу байна. Энэ их орж ирж буй хөрөнгө оруулалт нь зөвхөн хуучнаа сэргээхэд зарцуулагдаж байхаасаа илүү харин үйлдвэрлэл үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжихэд зарцуулагдвал ямар үр дүнд хүрч болохыг нэгэнт бодож шийдвэр гаргах цаг болсныг харуулж байна.*

**Ашигласан ном зүй**

1. Төрийн мэдээлэл сэтгүүл 2004,2005, 2006 он
2. YCEG “ Статистикийн эмхэтгэл ” 2005, 2006 он
3. Stermole F. J “ Economic evaluation and investment decision methods” 1989
4. С.Баатар “ Хөрөнгө оруулалтын менежмент “ 2000 он
5. А. Шагдарсүрэн “ Хөрөнгө оруулалтын эдийн засгийн асуудлууд “ 2005 он
6. МУИС-ийн ЭЗСургууль хамтын бүтээл “ Хөрөнгө оруулалтын бодлого, эрх зүйн зохицуулалт “ 2005 он
7. Д.Нар-Од “ Баруун бүсийн хөрөнгө оруулалтын судлагаа”-ны мэдээлэл, тайлан 2006 он